



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/493

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 ээлжит 5 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хариуцлага хамтын ажиллагаа" төрийн албан хаагчдын бүсийн сургалт, туршлага судлах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг 15,000,000 (Арван таван сая) төгрөгөөр баталсугай.

2. Дээрх зардлыг "Хамтын оролцоо-Хариуцлагатай засаглал" дэд хөтөлбөрийн Төрийн албан хаагчийн хөгжил манлайлал хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД